

Шинэ Зеландын “Хойд арал” гэдэг газар нэгэн далайн гахай зуны дэлгэр цагаар эрэг орчмоор эргэлдэж, тэнд сэлж байгаа хүмүүстэй тоглоно. Зан сайтай энэ хөөрхөн амьтныг Моко гэж өхөөрдөн нэрлэжээ.

Нарны гэрэлд далайн ус нүд гялбуулан нэгэн тогтуун өдөр эрэг дээр олон хүн цуглажээ. Тоглож наадах дуртай Моко ч цагтаа иржээ. Яг энэ үед далайн эргийн гүехэн усанд хоёр халим өөсдөж усны гүнд эргэн орж чадахгүй үхэх аюул тулгарчээ. Хүмүүс хөөрхий амьтдад туслахаар хувингаар ус зөөн, биен дээр нь асгаж байлаа. Тэр хавийн залуус хүчээ нийлүүлэн түлхээд ч аварга амьтдыг усанд нь оруулж чадахгүй байв.

Моко нөхцөл байдлыг дор нь ойлгож, хоёр халимд өвөрмөц сонин дуу чимээ өгөн удирдсаар усанд нь оруулжээ. Хоёр халим Мокогийн дуу сонсон, биеэ мурилзуулсаар их ус руугаа орлоо. Халим, далайн гахай хоёрыг ойлголцож байхад хүмүүс бүгд дуугаа хураан, гайхан биширч байлаа.

Нэгдүгээр хэсэг: Унших чадварыг сорьсон даалгавар:

1. “Тогтуун өдөр” гэсэн үгийн утгад тохирох хэсгийг олоорой.

- | | |
|---------------------------|-------------------------------------|
| А. Нар шарсан халуун өдөр | В. Салхи шороо багатай, намуун өдөр |
| Б. Хүйтэн сэрүүн өдөр | Г. Бороо шивэрсэн өдөр |

2. Нарны гэрэлд далайн ус нүд гялбуулсан нэгэн тогтуун **өдөр** эрэг дээр олон хүн цуглажээ. Гэсэн өгүүлбэрийн тодруулсан үг нь юуг заасан бэ?

- А. Үйл хөдлөл Б. Цаг хугацаа В. Гадаад төрх Г. Шинж чанар

3. Эхийн гол хэсгийн үйл явдлын зөв дарааллыг сонгоно уу.

1. Моко хоёр халимд өвөрмөц сонин дуу чимээ өгөн удирдсаар усанд нь оруулжээ.

2. Эргийн гүехэн усанд хоёр халим өөсдөж үхэх аюул тулгарчээ.

3. Хүмүүс бүгд дуугаа хураан, гайхан биширч байлаа.

4. Далайн гахай тэнд сэлж байгаа хүмүүстэй тоглоно.

- А. 4,2,1,3 Б. 1,4,3,2 В. 4,1,3,2 Г. 2, 4,1,3

4. Эхийн гуравдугаар цогцолборын үйл явдал нь юуны тухай өгүүлж байна вэ?

А. Моко нэртэй хөөрхөн амьтан хүмүүстэй тоглох дуртай.

Б. Халим далайн гахай хоёр ойлголцож усанд нь буцаан оруулжээ.

В. Хүмүүс хөөрхий амьтдад туслан хувингаар ус зөөн бие дээр нь асгажээ.

Г. Эргийн гүехэн усанд хоёр халим өөсдөж үхэх аюул тулгарчээ

5. Моко, хоёр халимд сонин дуу чимээ өгсний учир юу вэ?

А. Хоёр халимыг далайн эрэг дээр гаргахын тулд

Б. Хоёр халимыг усанд дуудан оруулахын тулд

В. Хүмүүсийг гайхан бишрүүлэхийн тулд

Хоёрдугаар хэсэг: Бичих чадварыг сорьсон даалгавар

1. Доорх үгийг үеэр таслан бичээрэй.

А. удирдсаар

2. Мокогийн хийсэн үйлүүдээс 3-ыг тоочин бичнэ үү?

-
-
-

3. “Ухаант туулай” сэдвээр 50-аас доошгүй үгтэй эх зохиож бичээрэй.

Төлөвлөлт:

Эхлэл хэсэг: Туулай хаана амьдарч, ямар үйл хийж байгаа талаар тоочин бичнэ.

Гол хэсэг : Туулай хэнд ямар тус хэрхэн хүргэж байгаа талаар үйл явдлыг өрнүүлэн бичнэ.

Төгсгөл хэсэгт: Туулайг ямар учраас ухаантай гэж бодсоноо дүгнэн бичнэ.

[illegible]